



ТӨВ АЙМГИЙН ӨНДӨРШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

ТАБ-ын Дарга, тэргүүлэх аудитор

Л.Жаргалсайхан

И-мэйл: jargsaihan_tuv@yahoo.com

Утас: 70272582

Факс: 01-272-22582

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

ХавсАралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудитын менежер:

О.Амаржаргал

И-мэйл: amaraa_tuv@yahoo.com

Утас: 70273465

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 99018619

И-мэйл: maits2009@yahoo.com

Аймгийн аудитын газрын хаяг:

Төв аймаг Зуунмод сум 1-р баг

Төрийн байгууллагуудын ордон

Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.3, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Өндөрширээт сумын ЗДТГазрын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд ТӨВ-2017/175 /СТА-ТШЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн Өндөрширээт сумын ЗДТГазрын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн Өндөрширээт сумын ЗДТГазрын төсвийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 03 дүгээр сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитын багийн гишүүн аудитор Т.Майцэцэг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн Өндөрширээт сумын ЗДТГазрын төсвийн 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 01 дугаар сарын 28-нд ТАБ-т ирүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллага аудитыг 2017 оны 03 дүгээр сарын 24-наас 2017 оны 03 дүгээр сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 03 дугаар сарын 26-нд Төв аймгийн Өндөрширээт сумын ЗДТГазрын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дүгээр зүйлийн 1-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын алба нь Тамгын газар байх бөгөөд дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ.” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тус хуулийн 33 дүгээр зүйлд тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 6.2.-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах үйл ажиллагааг төсвийн болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.38-д “төсвийн шууд захирагч “ гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” 16 дугаар зүйлийн 16.4.18-д төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн төсвийн шууд захирагч байна гэж заасны дагуу Төв аймгийн Өндөрширээт сумын ЗДТГазрын дарга Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг сумын ИТХурлаас баталж аймгийн Төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нийцлийн аудитын стандарт 4200, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төв аймгийн Өндөрширээт сумын ЗДТГазрын төсвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс Төв аймгийн Өндөрширээт сумын ЗДТГазрын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн шатанд аудитын хяналтын болон нарийвчилсан 9 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт шинээр гарсан хуулийн заалт, Сангийн сайдын журам зааварт орсон өөрчлөлтийг бүрэн тусгаж боловсруулсан. Сангийн яамнаас зөвшөөрөл бүхийн Санхүүгийн тооцоолох ХХК-ний бүртгэлийн асcolous програм ашигладаг байна.

Төсвийн шууд захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төв аймгийн Өндөрширээт сумын ЗДТГазрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллага нь дотоод хяналтын ажлын төлөвлөгөө тайлан ирүүлээгүй, ажиллаагүй. Иймд хөрөнгийн тооллого, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт зэрэг санхүүгийн механизмыг бүхэлд нь хянадаггүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн программаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Төв аймгийн Өндөрширээт сумын ЗДТГазрын Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

Төв аймгийн Өндөрширээт сумын ЗДТГазрын 2016 оны зарцуулах эрхийг аймаг, сумын ИТХ-аас 378176.4 мянган төгрөгийн санхүүжилт, эх үүсвэр авахаар баталж, сангийн яамнаас баталгаажуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар Өндөрширээт сумын ЗДТГазар нь 2016 онд батлагдсан төлөвлөгөөгөөр 300297.2 мянган төгрөг зарцуулахаас, гүйцэтгэлээр 298168.3 мянган төгрөгийг зарцуулж, төсвийн зарцуулаагүй татан төвлөрүүлсэн үлдэгдэл 2128.8 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд төвлөрүүлэх шилжүүлгээр тайлагнасан байна. Сумын ЗДТГазрын харилцах дансаар сум хөгжүүлэх сангийн оны эхний үлдэгдэл 26328.7 мянган төгрөг, зээл, зээлийн хүүгийн орлого 51787.2 мянган төгрөг нийт 78115.9 мянган төгрөгийг төвлөрүүлэн эргэн төлөгдөх зээлийн зардалд 61000.0 мянган төгрөг, үйл ажиллагааны зардалд 292.8 мянган төгрөг нийт 61292.8 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 16823.2 мянган төгрөгийг ЗДТГазрын харилцах данснаас төсөвт татан төвлөрүүлсэн.

ЗДТГазрын нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар 10157.9 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлэн зарцуулсан ба 5.4 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу 2015 оноос “shilendans.gov.mn” цахим сайтад зохих мэдээллийг оруулсан. ҮАГ-аас нэгдсэн удирдамжаар шилэн дансны хэрэгжилтэнд 2016 оны 10-р сарын байдлаар гүйцэтгэлийн аудит хийгдсэн. Аудитаар тус байгууллага нь шилэн дансанд 24 мэдээлэл байршуулахаас, 13 мэдээллийг байршуулсан 11 мэдээллийг байршуулаагүй байсан.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн шатанд мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, орлого, зардал зэрэг дансдад 9 горим сорил хэрэгжүүлсэн.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Эдгээр эрсдэлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зориулалтыг зөрчсөн, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төв аймгийн Өндөрширээт сумын ЗДТГазрын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, эхний 9 сарын завсарын аудитад тулгуурлан аудитын явцад цаг хугацааны хязгаардагдмал байдлаас шалтгаалан мөнгөн хөрөнгийн дансанд түүвэрлэн баримт үзээгүй, санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний дүнтэй ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийг э-тайлангийн бүлэгтэй төсвийн гүйцэтгэлийн тайлангийн дүнтэй тулган шалгахад сум хөгжүүлэх сангийн зээлийн эх үүсвэрийг ЗДТГазрын төсөвт 77879.2 мянган төгрөгөөр төлөвлөснийг мөнгөн гүйлгээний тайланд буюу төсвийн гүйцэтгэлийн тайланд зөрүүтэй тайлагнасан. Төсвийн тухай хуулийн 6.5.3.төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих боломжоор хангах; 7.4.Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр бэлтгэж, тайлагнана гэж заасантай нийцэхгүй байна. анхүүгийн тайлангийн батламж мэдэгдэл иж бүрэн байх, үнэн зөв байдал, бодит байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй

Шийдвэрлэсэн: Алдааг хүлээн зөвшөөрч аудитын явцад залруулсан.

2. Няравын гаргасан өвсний тайлангаас өвсний тооцоо бодолтыг давтан шалгахад 8488.5 мянган төгрөгийн өвс тэжээлийн үнэ төвлөрүүлэхээс МХСанд 1785.5 мянган төгрөг, Нэмэлт санхүүжилтийн дансанд 3384.9-216.0=3168.9 мянган төгрөгийн нийт 4954.4 мянган төгрөгийн орлого төвлөрүүлснийг болон аудитын явцад ирүүлсэн бэлэн мөнгөний тайлангаар өвс тээврийн хөлсөнд олгосон 2060.0 мянган төгрөг, ЗДТГазрын малын тэжээлийн үнэ 281.0 мянган төгрөгийг хасч тооцоход 1193.1 мянган төгрөгийн орлого дутуу төвлөрүүлсэн. Оны эцэст авлагыг данс бүртгэлд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын I хавсралтаар батлагдсан Төсвийн байгууллагын мөнгөн

кассын ажиллагааны журмын 2.6-д Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа /бусад орлого/-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Дутуу төвлөрүүлсэн 1193.1 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт бичив.

3. 2016.12.23-ний өдөр 3550.0 мянган төгрөгийг бэлнээр касс авч зарцуулахдаа өвс тэжээл татах тээврийн хөлсөнд Төрбатад 500.0 мянган төгрөг, Энэбишид 250.0 мянган төгрөг нийт 750.0 мянган төгрөг олгосон дүнгээс суутгасан ашгийн татвар 75.0 мянган төгрөгийг бэлэн мөнгөний тайланд давхар хасч тайлагнасан. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.1-д Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын I хавсралтаар батлагдсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 3.9-д мөнгөн кассын нярав нь анхан шатны орлого, зарлагын баримтыг үндэслэн мөнгөн кассын гүйлгээг хийнэ гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Бэлэн мөнгөний тайланд давхардуулан тайлагнасан 75.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт бичив.

4. Нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд Класнуэстайн майнинг ХХК-наас 300.0 мянган төгрөгийн БОНСэргээлтийн барьцааг байршуулсныг зориулалт бусаар зарцуулсан. БОНССангийн эх үүсвэрийг өглөгөөр бүртгэж тайлагнаагүй нь Төсвийн тухай хуулийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, НББ-ийн тухай хуулийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмын 4.2-д Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон “Байгал орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хуулийн 9.9-д заасан төсөл хэрэгжүүлэгчийн тусгай дансанд төсөл хэрэгжиж буй сум дүүргийн төрийн санд байршина. 4.3-д Тусгай дансанд төвлөрсөн хөрөнгийн орлогыг байгал орчны сайд сум дүүргийн эрх олгосон албан тушаалтны гарын үсэгтэйгээр зориулалтын дагуу зарцуулна.

Шийдвэрлэсэн: БОНССанд 300.0 мянган төгрөгийг төвлөрүүлэх төлбөрийн акт бичив

5. Бусад хангамжийн материал дансны жилийн эцсийн үлдэгдэл 12327.8 мянган төгрөгийн бараа материалыг тооллогын бүртгэлтэй тулган шалгахад тоологын бүртгэлээр 4650.0 мянган төгрөгийн материал хөрөнгө тооллогодож, 7677.8 мянган төгрөгийн хөрөнгийг тоолж бүртгээгүй, Нягтлан бодогчийн тооцоо бодсон актаар тооллогоор бэлэн байх үлдэгдэл 5550.0 мянган төгрөг гэж ня-бо, нярав, комиссын дарга гарын үсэг зурсан. Өвс тэжээлийн тооцоог давтан шалгахад 2016.04.30-ний өдрийн няравын тайлангийн үлдэгдэлд 676.0 мянган төгрөгийн өвс хивэг үлдэгдэлтэй байсан ба жилийн эцсийн тооллогын бүртгэлд бэлнээр тоологдоогүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.6-д эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч,

худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;, ТБОНӨТХуулийн 73-р зүйлийн 73.2-д Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана, Санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Тооллогын комисст хариуцлага тооцуулах бусад хангамжийн материал дансны тооллогыг дахин хийж тооцоог бодож ирүүлэхээр албан шаардлага бичив

6. Завсарын аудитаар ЗДТГазрын дарга нь хэрэглэгчийн ажиллах маршрут хуудасгүйгээр шатахууны зөвшөөрөлийн хуудсыг ШТС-д олгосон. Шатахууны зарлагыг тамгын газрын жолооч Отгонбатад бөөн бичдэг. Жолоочын замын хуудасны тооцоог ня-бо бодоогүй зөрчлийг арилгасан эсэхийг шалгахад зөрчлийг арилгаагүй, тайланд онд 12396.1 мянган төгрөгийн шатахууныг бүртгэсэн ба жолоочийн замын хуудас байхгүй, тооцоог бодоогүй байна. НББ-ийн тухай хуулийн 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй

Шийдвэрлэсэн: Шатахууны зардлын хувьд хязгаарлалттай дүгнэлт өгөв

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

7. Аж ахуйн материал дансанд 9188.1 мянган төгрөгийн барилгын материалыг ангилал буруу бүртгэсэн, малын тооцоо бодолтыг шалгахад ЗДТГ-ын малчин Д.Сэрээтэрийн малын зарлага адуу-1, хонь-21, ямаа-18 нийт 40 толгой малыг ямар шийдвэрээр хассан нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байна. НББ-ийн тухай хуулийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;

Шийдвэрлэсэн: Анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг данс бүртгэлд хөрөнгийн шинж чанарыг харгалзан материалын дансдад үнэн зөв ангилан бүртгэх зөвлөмж өгөв

8. 2016 оны жилийн эцсийн ЗДТГ-ын хөрөнгийг тооллох тооллогын комиссыг ЗДТГ-ын 2016.12.12-ний өдрийн №а/25 тоот тушаалаар Санхүү албаны дарга Г.Наранцэцэгээр ахлуулан 7 хүний бүрэлдхүүнтэйгээр томилсон. Тооллогын комиссын гишүүдэд ЗДТГ-ын нярав Х.Оюунчулуун, нягтлан бодогч Б.Оюунжаргал нарыг оролцуулан томилсон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4.4-д комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг

баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх; 72.5.1-д тооллого эхлэхийн өмнө эд хариуцагчаас эд хөрөнгийн орлого, зарлагын бүх баримтыг нягтлан бодогчид бүрэн шилжүүлсэн эсэхээр баталгаа гаргуулан авах ба нягтлан бодогч уг баримтуудыг хүлээн авсан эсэхийг шалгах; 73.2-д Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Тооллогын комисст ня-бо, нярав эд хариуцагч нарыг оруулахгүй байх зөвлөмж өгөв

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Материаллаг хэмжээний нийт 99521.2 мянган төгрөгийн алдаа илэрснээс 77879.2 мянган төгрөгийн алдааг хүлээн зөвшөөрч аудитын явцад залруулсан болно.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч аудитын хугацаанаас шалтгаалж эхний 9 сарын завсарын аудитад тулгуурлан шалгасан ба аудитаар өмнөх аудитаас өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжүүлэн ажилладаггүй хөрөнгийн тооллого, тооцоо бодолт, түүнд биет горим хэрэгжүүлэх, шатахууны тооцоо бодолт, дансны бичилт зэргийг дараагийн аудитаар шалгахаар тогтоов.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төв аймгийн Өндөрширээт сумын ЗДТГ-ын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар материаллаг хэмжээний 99521.2 мянган төгрөгийн, материаллаг бус 9188.1 мянган төгрөгийн буюу нийт 108709.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.Үүнд:

1. Материаллаг хэмжээний нийт 99521.2 мянган төгрөгийн алдаа илэрснээс 77879.2 мянган төгрөгийн алдааг хүлээн зөвшөөрч аудитын явцад залруулсан, зөрчлийг таслан зогсоох давтан гаргахгүй байх 1568.1 мянган төгрөгийн төлбөрийн акт, 7677.8 мянган төгрөгийн албан шаардлага бичив
2. Материаллаг бус 9188.1 мянган төгрөгийн алдааг таслан зогсоох зөвлөмж өгөв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төв аймгийн Өндөрширээт сумын ЗДТГазрын төсвийн 2015 оны санхүүгийн тайланд өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2016.06.05-ний өдрийн 05/67 тоотой ирүүлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Төв аймгийн Өндөрширээт сумын ЗДТГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 12396.1 мянган төгрөгийн шатахууны жолоочийн замын хуудасны тооцоог бодоогүй, хэрэглэгчийн ажиллах маршрут хуудасгүйгээр шатахууны зөвшөөрөлийн хуудсыг олгодог зэрэг нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн

байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй тул шатахууны зардлын хувьд Хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.

Аудитын явцад залруулагдаагүй материаллаг алдаа нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшин 4697.3 мянган төгрөгнөөс хэтэрсэн болно.

Дээрх алдаа, зөрчлийг эс тооцвол тус байгууллагын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 10 хуудас, байгууллагын санал .. хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЖАРГАЛСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

Т.МАЙЦЭЦЭГ